



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 342

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа орон нутаг дахь Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 67,500,000.00 (жаран долоон сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 55,843,220.50 (тавин таван сая найман зуун дөчин гурван мянга хоёр зуун хорин төгрөг тавин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар, “Увс-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга М.Мөнхбаяр, “Увс-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэгч захирал Ц.Цэдэнбал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн 342
дугаар тогтоолын хавсралт

Татварын ерөнхий газрын харьяа Орон нутаг дахь Татварын хэлтсийн үндсэн хөрөнөд бүртгэлтэй, цаашид ашиглах хугацааны үнийг шинэчлэн тогтоож балансаас балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа	Шилжүүлэх байгууллага	Хүлээж авах байгууллага
1	Ниссан навара маркийн, ХОУ 11-88 улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар - MNTCCUD40Z0016970	2012	47,500,000.00	47,500,000.00	-	5,000,000.00	2 жил	Ховд аймгийн Татварын хэлтэс	"Увс-АЗЗА" ТӨХК
2	Ниссан маркийн, 60-90 ДГА улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар - ACV403195730	2015	20,000,000.00	8,343,220.50	11,656,779.50			Дорноговь аймгийн Татварын хэлтэс	Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар
			67,500,000.00	55,843,220.50	11,656,779.50	5,000,000.00			
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		67,500,000.00 (жаран долоон сая таван зуун мянга)	55,843,220.50 (тавин таван сая найман зуун дөчин гурван мянга хоёр зуун хорин төгрөг тавин мөнгө)	11,656,779.50 (арван нэгэн сая зургаан зуун тавин зургаан мянга долоон зуун далан есөн төгрөг тавин мөнгө)	5,000,000.00 (таван сая)			